

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-13
1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	7-8
2.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай/	8-10
3.Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан, аудитын шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	10-12
4.Байнгын хорооны даргыг сонгох тухай	12-13

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 07 дугаар сарын 08-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 49 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар;

Чөлөөтэй: Ж.Батжаргал, Б.Батцэцэг, Б.Мөнхсоёл;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, З.Мэндсайхан.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “дээд хэмжээг” гэсний дараа “нэгэн зэрэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, 2 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2026 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө гэсэн зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалтын газрын зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан, аудитын шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөө, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, цөмийн энергийн хэлтсийн дарга Х.Санчигдорж, Үндэсний геологийн албаны Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа

Улсын Их Хурлын гишүүд Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан, аудитын шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 17 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 3

Бүгд: 18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 49 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18. 72 хувийн ирцтэй байна. Би ирцийг танилцуулъя.

Миний бие ирсэн байна. Алтанхуяг гишүүн өвчтэй байна. Аубакир гишүүн ирсэн байна. Д.Батбаяр гишүүн ирсэн байна. Р.Батболд гишүүн ирсэн байна. Ж.Батжаргал чөлөөтэй байна. Д.Батлут чөлөөтэй байна. Ерөнхийлөгчтэй хамт гадаад арга хэмжээнд оролцож байна. Б.Батцэцэг мөн Ерөнхийлөгчтэй хамт гадаад арга хэмжээнд оролцож байгаа юм байна. Ж.Баясгалан ирсэн байна. Х.Болормаа ирсэн байна. Х.Булгантуяа ирсэн байна. Ж.Ганбаатар Гадаад томилолттой. Г.Ганбаатар ирсэн байна. Б.Ганзориг ирсэн байна. Х.Ганхуяг ирсэн байна. Г.Дамдинням ирсэн байна. Заяабал ирсэн байна. Б.Мөнхсоёл гадаад томилолттой. П.Мөнхтулга ирсэн байна. З.Мэндсайхан өвчтэй. Д.Пүрэвдаваа ирсэн. Б.Түвшин ирсэн. Г.Тэмүүлэн ирсэн. Д.Цогтбаатар ирсэн. Б.Чойжилсүрэн ирсэн. Ийм ирцтэй байна.

Ирц 72 хувьтай байгаа учраас Төсвийн байнгын хорооны 25 оны 7 сарын 8-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар 4 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Эхний асуудал, Тогтвортой байдлын тухай энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

Хоёрт, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Гуравт, Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологи, судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан аудитын шалгалтад хамрагдах төрийн байгууллагуудын тогтолцоо, чиг үүрэг, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтэц зохион байгуулалт, геологи судалгааны ажлын төлөвлөлтийн талаар санал, дүгнэлт гаргах бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Дөрөвд, Байнгын хорооны дарга сонгох тухай гэсэн ийм 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой санал байна уу?

Алга байна.

Эхний асуудалдаа оръё. Эхний асуудлыг хэлэлцэхэд ирц хүндэтгэх шалтгаангүйгээс бүх хүмүүс оролцсон байх ёстой.

16.56 цаг

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсэг энэ үү? Н.Учрал, З.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Учрал сайд Тэргүүн шадар бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд ийм улсууд оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 10-д заасны дагуу төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл 2, 1 зүйлтэй бөгөөд хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Зарчмын зөрүүтэй 1 санал байна уу?

Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа юм байна шүү. Энэ 2 саналыг хураалгана. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд.

Зарчмын зөрүүтэй саналыг хураалгая. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн “дээд хэмжээг” гэсний дараа “нэгэн зэрэг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Ингэхгүй бол болохгүй юм байна лээ. Аль нэг нь өөрчлөлт орохоор төсөв тодотгох гээд байгаа юм шиг оргиод байгаа юм. Нэгэн зэрэг байж байж төсөв тодотгоно гэдэг санаа.

Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

18 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

2 дахь санал. 2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан. Энэ чинь 1 зүйлтэй гэсэн чинь яагаад 2 дугаар зүйл болоод явчав? Зүйл нэмэх юм байна шүү. Зүйл нэмэх заалт.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2026 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гэж байна.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

18 гишүүн санал хураалтад оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар энэ санал дэмжлээ.

Тэгэхээр 1 удаагийн хууль гарах гэж байна гэсэн үг шүү.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар танилцуулна.

17.07 цаг

Дараагийн асуудал. “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд. Ажлын хэсэг ажлын хэсгийг танилцуулчихъя.

Х.Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч. Ажлын хэсгийг оруулаарай. С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Хосбаяр Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Э.Түвшинжаргал Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал, Б.Одбаяр Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Жавхлан танилцуулна. Тийм үү? Учрал сайд танилцуулчихъя.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын Өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 5 дугаар зорилтод эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан Шинэ сэргэлтийн бодлогод нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх гэж заасан.

Үүний дагуу Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан шинэ тойрог зам буюу 1 дүгээр тойрог зам төслийг санхүүжүүлэх зорилгоор Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, ОНӨААТҮ-ын 2025 онд авах 260.3 сая ам.доллар-ын зээлийн 85 хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн.

Сангийн яамны зүгээс Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг судлан Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох эрсдэлийн үнэлгээг боловсруулсан бөгөөд Үндэсний аудитын газраас хөндлөнгийн аудит хийж дүгнэлт гаргасан болно.

Эрсдэлийн үнэлгээнд төслийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй төслийн орлогыг тооцоолохдоо хөдөлгөөний эрчмийг өөдрөгөөр төсөөлсөн зэрэг шалтгаанаар эрсдэлийн түвшний дундаж гэж үнэлсэн.

1 дүгээр тойрог зам төсөл нь Шинэ сэргэлтийн бодлого Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан бөгөөд тус төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын гол гудмуудын түгжрэл дунджаар 20 хувиар буурч, замын хөдөлгөөний дундаж хурд 23.3 хувиар өсөх ач холбогдолтой.

Түүнчлэн төслийг санхүүжүүлэхэд шаардагдах зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага болон 2025 онд Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээнд нийцэж байна.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай” Их Хурлын тогтоолын төсөл болон Сангийн яамны эрсдэлийн үнэлгээ, санал, дүгнэлт, Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлттэй танилцаж тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай “Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Чойжилсүрэн гишүүн горимын санал.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны дарга. Саяын санал хураалт дээр техникийн гацалт гарсан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ, санал хураалтдаа бэлдье. Энэ санал хураалтдаа бэлдье. Батболд гишүүн бэлдье. Батболдынхыг шинэчилчих.

Ингээд саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

18 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 66.7 хувиар энэ санал хүчингүй боллоо.

Дахиад санал хураалт явуулна.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор дахин санал хураалт явуулна.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 66.7 хувиар тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжлээ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулна.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

17.12 цаг

Гурав дахь асуудал. Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологи судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан, аудитын шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Заяабал гишүүн, тэгээд Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, цөмийн энергийн хэлтсийн дарга, Н.Мөнхбилэг Үндэсний геологийн албаны Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Ажлын хэсгийн дарга Заяабал гишүүн ажлын хэсгийн санал, дүгнэлтээ танилцуулъя.

Б.Заяабал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 25 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан аудитын шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот

хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж Байнгын хороонд, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар миний бие Заяабал, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Баясгалан, Ганбаатар, Дамдинням нар ажилласан.

Ажлын хэсэг аудитын шалгалтад хамрагдсан геологийн салбарын төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв санхүүжилтийн асуудал нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой хэрхэн уялдаж байгаа талаарх мэдээлэл. Түүнчлэн геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн боловсруулах шаардлагатай эсэх талаарх мэдээллийг холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллагуудаас тус тус гаргуулан авч танилцаж, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж 6 заалт бүхий Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд хүргүүлсэн болно.

Ажлын хэсгийн ажиллах хугацаанд бас Засгийн газар өөрчлөгдсөнтэй холбоотойгоор, салбарын сайд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор салбарын бодлогыг бас сайдын бодлоготой уялдуулах үүднээс бас ажлын хэсгийг өмнө нь хэлэлцэж байсан ажлын хэсгийг дахиж шинэ Засгийн газар бүрдсэнтэй холбоотойгоор шинэ сайд, салбарын сайд томилогдсонтой холбоотойгоор дахиж бодлогыг уялдуулан хэлэлцэж энэ удаагийн төслийг бас боловсруулсан гэдгийгээ бас дурдаж хэлэхийг хүсэж байна.

Ингээд тогтоолын төсөл, тараасан тогтоолын төсөлтэй танилцаж хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Заяабал гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Ажлын хэсгээс бас тогтоолын төсөл та бүгдэд тараасан байгаа.

Алга байна.

Үг хэлэх гишүүн алга байна. Санал хэлэх гишүүн алга байна.

Асуулт асуух гишүүн алга байна.

Ингээд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Тийм байна уучлаарай. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

18 гишүүн санал хураалтад оролцож, 13 гишүүн дэмжиж, Байнгын хорооны тогтоолын төсөл дэмжигдлээ 72.2 хувиар.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 72.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар дараагийн асуудлыг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны дарга сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын тухай хуулийн 26.3.Байнгын хороог Улсын Их Хурлаас 1 жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ. 26.4.Байнгын хорооны даргыг Улсын Их Хуралд сонгогдсон, ажилласан туршлагыг харгалзан тухайн Байнгын хороо сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэсэн ийм заалттай байна.

Ингээд Монгол Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэ нэр дэвшигчийг танилцуулна. Бат-Эрдэнийн микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд Төсвийн байнгын хорооны даргад Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Хассуурийн Ганхуягийг нэр дэвшүүлж байна. Хассуурийн Ганхуягийн танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Хассуурийн Ганхуяг нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. 1994 онд Нийслэлийн Монгол-Оросын хамтарсан 3 дугаар дунд сургууль, 1999 онд МУИС-ийн Олон улсын харилцааны сургуульд Гадаад албаны ажилтан, 2014 онд АНУ-ын Харвардын их сургууль Захирлуудад зориулсан бизнес удирдлага, менежмент, ерөнхий менежмент, 2015 онд БНСУ-ын Үндэсний академи Олон улсын эдийн засаг, БНСУ-ын Үндэсний академи олон улсын эдийн засгийн чиглэлээр суралцсан. 2018 онд Канад Улс Бритиш Колумбийн их сургууль Уул уурхайн инженер, тогтвортой хөгжлийн засаглал чиглэлээр суралцсан байна.

2003 оноос “Херо” группийн үүсгэн байгуулагч, Удирдах зөвлөлийн дарга, 2008-2014 онд “Рэмикон” ХХК-ийн ТУЗ-ийн дарга, 2010-14 онд Уул уурхайн ассоциацийн Удирдах зөвлөлийн гишүүн, 2010 оноос Архангай аймгийн Тариат сумын Нутгийн зөвлөлийн дарга, 2013 оноос “СЕО” клубийн гишүүн, 2013 оноо “ҮРО” Монгол Улс дахь салбар байгууллагын гишүүн, 2012-2014 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын орон тооны бус зөвлөх, 2015-2017 онд МЭЗФ-ийн зохион байгуулах комиссын гишүүн, 2017 онд Монгол Ардын намын бага хурлын гишүүн, 2018 оноос БГД-ийн Монгол Ардын намын тэргүүлэгч, 22 дугаар хорооны намын хорооны дарга, 2019 онд 3х3 UB клубийн эзэн, УЗ-ийн гишүүн, 2019-2020 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын орон тооны бус зөвлөх, 2020-24 оноос Улсын Их Хурлын гишүүнээр 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Эрхэм гишүүд харгалзан үзэж, санал хураалтад оруулна уу.

Ц.Даваасүрэн: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.6 дахь заалтад Улсын Их Хурлын гишүүн нь энэ хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын хороо, Дэд хорооны дарга Улсын Их Хурлын сонгуульт бусад албан тушаалд сонгогдох, нэрээ дэвшүүлэх эрхтэй гэж заасан юм байна. Энэ заалтын дагуу Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх, нэрээ дэвшүүлэх саналтай хүн байна уу?

Алга байна. Алга байна уу?

Нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгье.

Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг.

Алга байна, алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хорооны дарга сонгох санал хураалтад бэлтгэе. Цогтбаатар гишүүнийх болоогүй байна шүү. Гишүүд ээ санал хураалт.

Төсвийн байнгын хорооны даргаар. Цогтбаатарынх орохгүй байгаад байх юм. Ороогүй байгаад байна. Орчихлоо.

Төсвийн байнгын хорооны даргаар Хассуурийн Ганхуягийг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 83.3 хувиар санал дэмжигдлээ.

Хөөе гишүүд байж байгаарай, байж байгаарай хөөе.

Байнгын хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна.

Ингээд өнгөрсөн хугацаанд бас Төсвийн байнгын хорооны дэмжиж, хамтарч ажилласан та бүхэндээ талархал илэрхийлье.

Өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудал дууслаа. Баярлалаа.

17.18 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

